



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн үндсэн үйл ажиллагааны давсан орлогоор худалдан авсан, нийт 71,800,000.00 (далан нэгэн сая найман зуун мянган) төгрөгийн үнэлгээгээр хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгө, түүний газрын эрх болон хөдлөх хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Л.Баттөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 02 дугаар сарын 31 ны өдрийн
29 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НӨГДСЭН ЭМНЭЛГИЙН
БАЛАНСАД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1.Барилга байгууламж					
1	Сувиллын байр, Аварга тосон байр-1	ш	1	9,500,000.00	9,500,000.00
2	Сувиллын байр, Аварга тосон байр-2	ш	1	9,500,000.00	9,500,000.00
3	Сувиллын байр, Аварга тосон байр-3	ш	1	9,500,000.00	9,500,000.00
	Дүн				28,500,000.00
2.Тээврийн хэрэгсэл					
4	Хьюндай старекс	ш	1	33,800,000.00	33,800,000.00
	Дүн				33,800,000.00
3.Биет бус хөрөнгө (газрын эрх)					
5	Газрын эрх	м2	1000	9,500,000.00	9,500,000.00
	Дүн				9,500,000.00
	Нийт дүн				71,800,000.00 (далан нэгэн сая найман зуун мянган)